

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
2021, 2022 ОНЫ ЭХНИЙ 4 САРЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2022.05.11

Алтай хот

Эх, хүүхдийн эрүүл мэнд. Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 4 сарын байдлаар 308 эх амаржиж, 310 хүүхэд мэндэллээ. Нялхсын эндэгдэл 19.4 болж, өмнөх оноос 3.6 промилиор, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 8 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оноос 7.8 промилиор тус тус өссөн байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 4 сарын байдлаар 308 эх нярайлж өнгөрсөн оны мөн үеэс 134 тохиолдлоор буурсан бөгөөд нийт төрөлтийн 94.8 хувь нь лавлагаа төвийн төрөлжсөн мэргэжлийн эмчийн тусламжид төрсөн байна. Нэгдсэн эмнэлэгт 171 эх сумаас ирж төрсөн нь өмнөх оны мөн үеэс 95 тохиолдлоор буурсан ба нэгдсэн эмнэлэгт төрсөн эхийн 58.6 хувийг эзэлж байна.

2022 оны эхний 4 сарын байдлаар жирэмсний хяналтад шинээр 338 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдсан ба 89.1 хувь нь эхний 3 сартайд, 10.1 хувь нь 4-6 сартайд, 0.9 хувь нь 7 ба түүнээс дээш сартайдаа хяналтад орсон байна. Эхийн эндэгдэл, төрөлхийн тэмбүүгийн тохиолдол гаргалгүй ажиллаж байна.

2022 оны эхний 4 сарын байдлаар аймгийн хэмжээнд 310 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 134 хүүхдээр буюу 30.2 хувиар буурчээ. Амьд төрсөн хүүхдийн 171 буюу 55.2 хувь нь хүү, 139 буюу 44.8 хувь нь охин байна. Амьд төрсөн хүүхдийн 4.2 хувь нь бага жинтэй буюу 2500 гр-аас доош жинтэй төрсөн.

Нас баралтын үзүүлэлтүүд. 2022 оны эхний 4 сарын байдлаар нас баралтын 108 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 16 тохиолдлоор нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Нас барсан хүний 52.8%, нь эрэгтэй, 47.2 хувь нь эмэгтэй байна. Нийт нас баралтын 30.6% нь эмнэлэгт нас барсан бөгөөд 24.2 хувь нь хоног болоогүй байна.

Нийт нас баралтын 32 буюу 29.6 %-ийг хорт хавдрын, 11 буюу 10.2 хувь нь осол гэмтлийн шалтгаантай байна.

Амбулатори, стационарын тусламж үйлчилгээ. 2022 оны эхний 4 сарын байдлаар нийт 85 058 үзлэг хийгдсэний 16.9% нь урьдчилан сэргийлэх үзлэг, 65.2% нь өвчний учир амбулаторит, 4.6% нь идэвхтэй хяналт, 10.9% нь гэрийн идэвхтэй үзлэг, 2.4% нь гэрийн дуудлагын үзлэг тус тус эзэлж байна.

Хэвтэн эмчлүүлэгчдийн тусламж үйлчилгээ. Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 4 сарын байдлаар эмнэлэгт 5 649 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлж, 42 617 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 7.5 байна.

Түргэн тусламжийн дуудлага.

2022 оны эхний 4 сарын байдлаар 4 114 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч үйлчилснээс 816 буюу 19.8 хувь алсын дуудлага, 83 буюу 2.0 хувийг осол гэмтлийн дуудлага эзэлж байна.

Халдварт өвчин. 2022 оны эхний 4 сарын байдлаар 5695 тохиолдол бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 5560 тохиолдол буюу 10000 хүн амд 949.6-оор өсчээ. Энэ нь Ковид-19 халдвар гарсантай холбоотой бөгөөд нийт халдварт өвчний 5662 буюу 99.4 хувийг коронавирусийн халдвар эзэлж байна. Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 4 сарын байдлаар 9 төрлийн 5695 цочмог халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10.000 хүн амд 972.9 байна.

Халдварт өвчний нас баралт 3 тохиолдол бүртгэгдсэн нь коронавирусийн халдварын шалтгаантай байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ , ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТЭС